



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 4/28

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжих "Х.5.2.1 Нийгмийн даатгалын байгууллагуудын барилгын их засвар /улсын хэмжээнд/ 1,000.0 сая.төг" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т шилжүүлсүгэй.

2. Их засварын төсөл, арга хэмжээг холбогдох хуулийн дагуу шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийн мэдээ, тайланг хуулийн хугацаанд нь ирүүлж байхыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлэн хэрэгжүүлж буй их засварын төсөл, арга, хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Бодлого төлөвлөлтийн газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34, Цахим шуудан: mlsp@mongolnet.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn


2018.03.28 № 1/903
танай _____-ны № _____-т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Д.ЗОРИГТ ТАНАА

Эрх шилжүүлэх тухай

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/78 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалаар батлагдсан “Х.5.2.1 Нийгмийн даатгалын байгууллагуудын барилгын их засвар /улсын хэмжээнд/ 1,000.0 сая төгрөг” төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг үүгээр шилжүүлж байна.

Эрх шилжүүлж буй их засварын төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллана уу.



С.ЧИНЗОРИГ